



**“УХААЛАГ ЗАСАГ 2 ТӨСӨЛ” (ДУГААР 70-90 МН)-ИЙН  
ТӨСЛИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
2025 ОНЫ ТАЙЛАН**

***(Хураангуй)***

**2025.01.20**

**“УХААЛАГ ЗАСАГ 2 ТӨСӨЛ” (ДУГААР 70-90 МН)-ИЙН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН  
2025 ОН**

**1. Хураангуй**

|                                                    |                                                                                                                                           |
|----------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Төслийн нэр, дугаар:                               | Ухаалаг засаг 2 төсөл (70-90МН)                                                                                                           |
| Хөгжлийн түнш/санхүүжүүлэгч байгууллага:           | Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци (ОУХА)                                                                                       |
| Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:                    | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам                                                                                              |
| Санхүүжилтийн эх үүсвэр:                           | - ОУХА-ийн хөнгөлөлттэй зээл 29.5 сая зээлжих эрх буюу 40.7 сая ам.доллар<br>- Монгол Улсын Засгийн газрын санхүүжилт (НӨАТ-ын хөнгөлөлт) |
| Санхүүжилт:                                        | - 29.5 сая зээлжих эрх буюу 40.7 сая ам.доллар<br>- Монгол Улсын Засгийн газрын санхүүжилт (НӨАТ-ын хөнгөлөлт) 1.0 сая ам.доллар          |
| Санхүүжилтийн хэлэлцээрийг соёрхон баталсан огноо: | 2023.01.20                                                                                                                                |
| Төслийн эхлэх, дуусах хугацаа:                     | 2023.05.24-2027.07.30                                                                                                                     |
| Тайланд хамрагдах хугацаа:                         | 2025.01.01-12.31                                                                                                                          |

**2. Төсөл, арга хэмжээний үйл ажиллагааны ерөнхий мэдээлэл, өөрчлөлт, түүний нөлөөлөл**

**2.1. Төсөл, арга хэмжээний үйл ажиллагааны ерөнхий мэдээлэл**

**2.1.1. Төслийн зорилго, бүтэц**

Ухаалаг засаг 2 төслийн зорилго нь иргэд, аж ахуйн нэгжид үзүүлэх төрийн цахим үйлчилгээний хэрэглээ, үр ашгийг сайжруулах, цахим ур чадвар болон дижитал технологи суурьтай ажлын байрыг нэмэгдүүлэхэд оршино.

Төслийн хөгжлийн зорилгын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр санхүүжилтийн хэлэлцээрт тусгажээ.

**Бүрэлдэхүүн хэсэг 1. Дижитал шилжилтийн таатай орчныг бүрдүүлэх**

- Дижитал шилжилтийн талаарх бодлого, дүрэм, журмыг сайжруулах
  - Дижитал шилжилттэй холбоотой хууль, эрх зүй, зохицуулалт, бодлого, институтын тогтолцоог бэхжүүлэхэд шаардлагатай дүн шинжилгээ хийх, техникийн туслалцаа үзүүлэх;
  - Цахим шилжилт хийхэд шаардлагатай дүрэм журмуудын хийдэл, зөрчлийг тогтоож, санал боловсруулах.

**Бүрэлдэхүүн хэсэг 2. Дижитал засгийн шилжилтийг нэвтрүүлэх**

- Төрийн цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлж, үр ашигтай байдлыг дээшлүүлэх, стратегийн үйлчилгээ үзүүлэх

- Төрийн үйлчилгээг цахимжуулж, e-Mongolia порталд байршуулах, төрийн цахим үйлчилгээний зааварчилгааг боловсруулах;
- Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн үйл ажиллагааг шинэчлэх, хиймэл оюун ухааны шийдлийг нэвтрүүлэх, системийн шаардлагыг боловсруулах, системийг нэвтрүүлэхэд техникийн дэмжлэг үзүүлэх, Монгол Улсын төрийн худалдан авалтын хуулийн шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлэх, ялангуяа цахим шийдлүүдийг нэвтрүүлэхэд шаардлагатай хууль эрх зүйн актуудыг шинэчлэн боловсруулахад дэмжлэг үзүүлэх;
- Бизнес эрхлэх тусгай зөвшөөрөл онлайнаар олгох нэг цонхны систем хөгжүүлэх, системийн шаардлагыг боловсруулах, системийг нэвтрүүлэхэд техникийн дэмжлэг үзүүлэх, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд процессын шинжилгээ хийх, процессын шинжилгээ хийхэд хуулийн дэмжлэг үзүүлэх;
- Ашиг сонирхлын зөрчил, орлого, хөрөнгийн мэдүүлгийн системийн хоёр дахь үе шатыг хэрэгжүүлэх;
- Үндэсний аялал жуулчлалын нэгдсэн платформыг шинэчлэх,
- Засгийн газрын шийдвэрийн цахим систем болон архивын цахим систем хөгжүүлэх, дижитал кабинетийн тогтолцоог хөгжүүлэх, хиймэл оюун ухааны шийдлийг нэвтрүүлэх боломжийг бий болгох;
- Байгаль орчны мэдээллийн сангийн системийг шинэчлэн хөгжүүлэх;
- Монгол Улсын төрийн дижитал шилжилтийн түвшинг үнэлэх;
- Олон улсын үнэлгээний системийг хөгжүүлэх;
- Үндэсний дата төв болон түүний Нөөц дата төвийг шинэчлэх
  - Үндэсний дата төв, түүний Нөөц дата төвийн техник хангамжийн хүчин чадлыг сайжруулах;
  - Төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем (ХУР)-ийг тархсан бүтцэд шилжүүлэх, техникийн шаардлагыг боловсруулах, гэрээний хэрэгжилтийг хянахад дэмжлэг үзүүлэх;
  - Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийн суурь системийг шинэчлэх;
  - Интернэтийн харилцан холболтын төхөөрөмжийг шинэчлэх;
  - Хөдөө орон нутгийн харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулах;
  - Цахим шуудангийн линзензээр хангах замаар төрийн байгууллагууд хооронд цахимаар мэдээлэл солилцоход дэмжлэг үзүүлэх;
  - Арилжааны үүлэн тооцооллын үйлчилгээ ашиглах боломжийг үнэлэх, төвлөрсөн бус дэд бүтэц бүхий захын тооцооллын загварыг нэвтрүүлэх;
  - Холбогдох төрийн байгууллагуудын дундын хэрэглээнд зориулсан нийтлэг үйлчилгээ идэвхжүүлэгчийг нэмэх.
- Үндэсний кибер аюулгүй байдлын онцгой нөхцөлд хариу арга хэмжээ авах Мэдээллийн аюулгүй байдлын багийн чадавхыг нэмэгдүүлэх, Улсын бүртгэлийн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг бэхжүүлэх

- Үндэсний хэмжээний кибер аюулгүй байдлын яаралтай тусламжийн багийг байгуулж, ажиллуулахад дэмжлэг үзүүлэх;
- Үндэсний хэмжээний кибер халдлагад хариу үзүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх;
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын нөөц төвийг техник хангамж, мэдээллийн сан аюулгүй байдлын лицензээр хангах замаар системийн аюулгүй байдлыг бэхжүүлэх.
- Төрийн их өгөгдлийн дэд бүтэц бий болгох, хиймэл оюун ухааны шийдлийг нэвтрүүлэх техникийн орчныг бүрдүүлэх
  - Төрийн "Их өгөгдлийн сан" үүсгэх, хэрэгжүүлэх;
  - Үндэсний дата төвийн нөөц төвийн "Б" өрөөг тоноглох;
  - Хиймэл оюун ухааны суурь дэд бүтцийг бий болгох, үүсгэх, хэрэгжүүлэх.

### **Бүрэлдэхүүн хэсэг 3. Дижитал эдийн засгийн хөгжлийг дэмжих**

- Төрийн албан хаагчид, иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх
  - Төрийн болон төрийн захиргааны албан хаагчдын онлайн сургалтын порталыг сайжруулах;
  - Зорилтот бүлэг (ахмад настан)-ийн иргэдэд дижитал ур чадварын үндсэн ба шаардлагатай мэдлэгийг олгон цахим ур чадварыг дээшлүүлэх туршилтын хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Залуучуудад зориулсан дижитал технологид суурилсан ажлын байр бий болгох;
  - Дижитал эдийн засгийн өсөлтийг дэмжих, залчуудад зориулсан дижитал технологид суурилсан ажлын байр бий болгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

### **Бүрэлдэхүүн хэсэг 4. Төслийн удирдлага, зохион байгуулалтад дэмжлэг үзүүлэх**

### **Бүрэлдэхүүн хэсэг 5. Онцгой нөхцөлд хариу арга хэмжээ авах төлөвлөгөө**

#### **2.1.2. Төслийн хэрэгжүүлэгч, хамтран хэрэгжүүлэгч байгууллага**

Төслийн хэрэгжүүлэгч байгууллага нь Цахим хөгжил, инновац, харилцааны холбооны яам бөгөөд төслийн хүрээнд төлөвлөсөн арга хэмжээг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх, төсөв, хөрөнгийг зохистой, үр ашигтай зарцуулах, төслийн үйл ажиллагаа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавих, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүрэгтэй.

Төслийн хүрээний дэд төсөл, арга хэмжээ дараах байгууллагууд хамтран хэрэгжүүлж байна. Үүнд:

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар;
- Эдийн засаг, хөгжлийн яам;
- Сангийн яам;
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам;
- Соёл, спорт, аялал жуулчлалын яам;
- Авлигатай тэмцэх газар;

- Төрийн худалдан авах ажиллагааны газар;
- Улсын бүртгэлийн ерөнхий газар.

### **3. Үйл ажиллагааны үнэлгээ**

#### **3.1. Өнөөгийн хэрэгцээтэй нийцтэй, хамааралтай байдал**

Цахим засаглалыг хөгжүүлэх хүрээнд: Монгол Улсын Засгийн газраас цахим засаглалыг хөгжүүлэх бодлогын баримт бичгийг баталж, холбогдох төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж ирсэн. НҮБ-аас 2 жил тутамд гардаг цахим засаглалын хөгжлийн индексээр Дэлхийн 193 орноос 2020 онд 92 дугаар, 2022 онд 74 дүгээр, харин энэ онд (2024 онд) огцом урагшилж 47 дугаар байранд оржээ. Энэ ахицад цахим үйлчилгээний индекс 2022 онд 0.6263-аас 2024 онд 0.822, цахилгаан холбооны дэд бүтцийн индекс 0.6973-аас 0.9374 болж, голлох нөлөө үзүүлжээ.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Цахим гарын үсгийн тухай, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулиуд 2021 онд батлагдсан нь цахим засаглалын хөгжлийг хурдасгах орчин бүрдсэн. Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал И-Монгол системийг 2020 онд нэвтрүүлж, хэрэглээг нэмэгдүүлсэн. Үүний зэрэгцээ цахим үйлчилгээг үзүүлэх тогтвортой техникийн орчныг бүрдүүлсэн.

Монгол Улсын цахим засаглалын хөгжлийн индексийн байрыг тогтвортой хадгалах, ахиулахад дээрх хуулийн хэрэгжилтийг хангах, дагаж мөрдөх журам, аргачлал болон бусад холбогдох бодлогын баримт бичгүүдийг боловсруулж, дижитал шилжилт хийх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд төслийн 1 дүгээр бүрэлдэхүүн хэсгийн зорилтууд чухал үүрэг гүйцэтгэнэ. Олон улсад тавигддаг цахим үйлчилгээний шаардлагыг боловсруулж, үүнд нийцүүлсэн үйлчилгээг И-Монгол системд оруулах, стратегийн үйлчилгээнүүд буюу цахим зөвшөөрөл, цахим худалдан авалтын ажлуудыг 2.1 дэд бүрэлдэхүүнд хэсгийн хүрээнд хийгдэнэ.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах хүрээнд: Олон Улсын Цахилгаан холбооны байгууллагаас “Кибер аюулгүй байдлын индекс”-ээр Монгол Улс 2024 онд 172 орноос 3 дугаар бүлэг (76-125 дугаар байр)-т орж, “Түвшин 3: Бэхжиж байгаа”<sup>1</sup> бүлэгт оржээ. 2024 оны энэ тайлангаар УИХ-аас “Кибер аюулгүй байдлын тухай хууль”-ийг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталсан нь Монгол Улсад кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоог бий болгох, бодлого, зохицуулалтын орчныг боловсронгуй болгох томоохон алхам болсон юм. Энэхүү хуулийн хэрэгжилтийг ханган ажиллахад дагаж мөрдөх журам, аргачлал, стандартыг боловсруулан батлуулах, хүний нөөцийг чадавхжуулах, тогтолцоог бий болгох зайлшгүй шаардлага тулгарч байна. Төслийн бүрэлдэхүүн хэсэг 2.3-ын хүрээнд энэ асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.

---

<sup>1</sup> Англи нэршил: Tier 3: Establishing

Бүх нийтийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх хүрээнд: “КОВИД-19” цар тахлын нөхцөл байдал Монгол Улсын төдийгүй Дэлхийн эдийн засаг, амьдралын хэв маягт нөлөөлж байна. Цар тахлаас үүдсэн хязгаарлалт, сорилт бэрхшээлүүд нь цахим технологийн хэрэглээг дэмжих таатай боломжийг бий болгож төрийн үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулж, дэд бүтцийг сайжруулах, хэрэглээг нэмэгдүүлэх, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, дижитал ур чадварыг дээшлүүлэх хэрэгцээ шаардлага илүү ихээр тавигдаж байна.

Дэлхий нийтэд цахим шилжилтийн давалгаа нөмөрч байгаа энэ үед компьютер, хөдөлгөөнт төхөөрөмж болон бусад тоног төхөөрөмжтэй харьцах, хэрэгцээт мэдээллийг эрж хайх, олж авах чадвартай хүн энгийн чадвартай хүнд тооцогдож байна. Цахим орчны давуу талыг ашиглан мэдлэгээ тэлэх, ажил амьдралын хэрэгцээ шаардлага, асуудлаа зорилтот аппликэйшнүүдийг ашиглан шийдвэрлэж чадаж байгаа нь хувь хүний өрсөлдөх чадвар, амьдралын аз жаргалын индексийг нэмэгдүүлж байна

Иргэдэд цахим ур чадварыг эзэмшүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулалт хийж чадваржуулах, мэдээллийн технологийн суурь мэдлэгийг дээшлүүлэх боломж олгох, шилжилтийн үеийг даван туулахад нь дэмжлэг туслалцаа үзүүлэх хэрэгцээ шаардлага гарч байна.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Үндэсний статистикийн хороотой хамтран 2021 онд хийсэн “Монгол Улсын өрхийн мэдээлэл, харилцаа холбоо технологийн тоног төхөөрөмжийн байдал, харилцаа холбооны технологийн үйлчилгээний хэрэглээ”-ний түүвэр судалгаагаар иргэдийн цахим ур чадвар 43.8%-тай гарсан нь иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай нотолж байна.

Төслийн 3 дугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд ахмад настай иргэдийн цахим ур чадвар нэмэгдүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

Дижитал эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх хүрээнд: Засгийн газраас уул уурхайн бус салбарын, ялангуяа ажлын байр бий болгох өндөр чадавхтай салбаруудын хөгжлийг дэмжихэд онцгой анхаарч байна. Хэдийгээр эрдэс баялгийн нөөц нь Монгол Улсын хөгжлийн гол тулгуур байх боломжтой боловч уул уурхайн салбар нь ашигт малтмалын нөөцийн эзэмшил, ашиглалтын тодорхойгүй байдлаас үүдсэн улс төрийн асуудлууд, хөрөнгө оруулагчид, хөрөнгийн зах зээлийн тодорхойгүй байдал, хөдөлмөр эрхлэлтийн доогуур түвшин бий болгодог. Уул уурхайн салбарын автоматжуулалтын улмаас улсын хэмжээний нийт ажиллах хүчний дөнгөж 4 хувь нь энэ салбарт ажилладаг бий.

Иймд эдийн засгийг олон төрөлжүүлж, шинэ хөдөлгүүр бий болгох, уул уурхайн бус салбарын бүтээмжийг дээшлүүлэх, ажлын байр бий болгох нь улс орны эдийн засагт чухал нөлөөтэй. Төслийн 3 дугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд цахим суурьтай ажлын байр бий болгохыг зорьж байна.

### **3.2. Төсөл, арга хэмжээнээс хүлээгдэж байгаа үр нөлөө**

Ухаалаг засаг 2 төслийн дээрх дурьдсан зорилтуудыг хэрэгжүүлж дараах үр нөлөө бий болно. Үүнд:

- Төрийн албан хаагчдын дижитал ур чадвар нэмэгдэж, төрийн цахим үйлчилгээг иргэд, бизнес эрхлэгчдэд үзүүлэх чадамжтай болно;
- Төрийн цахим үйлчилгээний хэрэглээ нэмэгдэнэ;
- Цахим зөвшөөрөл, цахим худалдан авалтыг бэхжүүлж, төрийн хүнд суртал буурна;
- Иргэд төрийн шийдвэр гаргалтад цахимаар оролцох боломж бүрдэнэ;
- Төрийн үйлчилгээний суурь дэд бүтэц, үндсэн болон дэмжих системийг өргөтгөн хөгжүүлж, Үндэсний дата төвийн хүчин чадлыг нэмэгдүүлж, үүлэн шийдлийг нэвтрүүлж, цахим үйлчилгээг дэмжих мэдээллийн технологийн нэгдсэн хөрөнгө оруулалтаар төсвийг хэмнэнэ;
- Кибер аюулгүй байдлыг хангах хүчин чадал нэмэгдэж, Монгол Улсын эмзэг мэдээллийг хамгаалах нөхцөл бүрдэнэ;
- Дижитал технологид суурилсан ажлын байр бий болно.

### **3.3. Төсөл, арга хэмжээний зорилт, үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт**

Ухаалаг засаг 2 төслийн үр дүнг хөгжлийн зорилтын 4 үндсэн шалгуур үзүүлэлт, дунд хугацааны 11 шалгуур үзүүлэлтээр тус тус хэмжинэ. Төслийн нийт хугацаанд хүрэхээр зорьж буй үр дүнг жил бүр эдгээр шалгуур үзүүлэлтээр хэмждэг.

Энэхүү тайлангийн 3-т дурдсаны дагуу төслийн бүтцийн өөрчлөлтийн хүрээнд зарим дэд төслүүд цуцлагдсан бөгөөд эдгээрт шууд хамаарах шалгуур үзүүлэлтүүд хасагдахаар төлөвлөгдөж байна.

Тайлант хугацааны эцсийн байдлаар эдгээр 15 шалгуур үзүүлэлтээс 3 шалгуур үзүүлэлт өссөн дүнгээр дараах түвшинд хүрчээ. Өмнөх жилтэй харьцуулахад цахим ур чадварыг нэмэгдүүлэх зорилтот бүлгийн иргэдийн тоо бага зэрэг нэмэгдсэн байна.

| Шалгуур үзүүлэлтийн нэр                                                                  | Суурь түвшин | Хүрсэн түвшин (2024.12.31) | Хүрсэн түвшин (2025.12.31) | Эцсийн зорилтот түвшин (2027.07.30) |
|------------------------------------------------------------------------------------------|--------------|----------------------------|----------------------------|-------------------------------------|
| <b>Төслийн хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлт</b>                                        |              |                            |                            |                                     |
| Төслийн сургалтад хамрагдсан төслийн үр шим хүртэгчдийн дижитал ур чадвар дээшилсэн хувь | 0            | 5.9% <sup>2</sup>          | 6.02%                      | 30%                                 |
| Үүнээс эмэгтэйчүүдийн                                                                    | 0            | 8.2%                       | 8.35%                      | 30%                                 |

<sup>2</sup> Ахмад настай иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх хөтөлбөрийн сургалтад хамрагдсан ахмадын өөрсдийгөө үнэлэх асуулгын дүн. Эдгээр ахмадуудын цахим ур чадвар 49.9% өссөн. Нийт 10,000 хүн сургахаас дундажийг тооцоолж гаргав.

|                                                                                                                |   |                    |       |        |
|----------------------------------------------------------------------------------------------------------------|---|--------------------|-------|--------|
| эзлэх хувь                                                                                                     |   |                    |       |        |
| <b>Бүрэлдэхүүн хэсэг 1: Цахим шилжилтийн таатай орчныг бүрдүүлэх</b>                                           |   |                    |       |        |
| Дижитал хөгжлийг дэмжих бодлого, зохицуулалтын тоо                                                             | 0 | 5                  | 5     | 5      |
| <b>Бүрэлдэхүүн 3. Дижитал эдийн засгийн хөгжлийг дэмжих</b>                                                    |   |                    |       |        |
| Технологийн хоцрогдолтой иргэдэд зориулсан дижитал ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамрагдан суралцагсдын тоо | 0 | 1,183 <sup>3</sup> | 1,208 | 10,000 |
| Үүнээс эмэгтэйчүүдийн тоо                                                                                      | 0 | 794                | 808   | 5,000  |

Дээр хүснэгтийн Дижитал хөгжлийг дэмжих бодлого, зохицуулалтын баримт бичгүүдийг нэрлэвэл дараах 2 хууль, 3 журам орно. Үүнд:

- Хууль:
  - [1] Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль;
  - [2] Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/.
- Журам:
  - [1] Эрүүл мэндийн болон ЦХХХ-ны сайдын 2024.03.26-ны А/138, А/37 тоот хамтарсан тушаалаар баталсан Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний програм хангамжид тавигдах шаардлага болон эдгээр программ хангамжид үнэлгээ хийх, шаардлагад нийцсэн программ хангамжийг мэдээлэх журам;
  - [2] Засгийн газрын 2024 оны 100 дугаар тогтоолоор баталсан Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах хадгалах, аюулгүй байдлыг хангах журам;
  - [3] Засгийн газрын 2024 оны 141 дүгээр тогтоолоор баталсан Бүх нийтийн тоон бичиг үсгийн бүтцийн хүрээ

Дижитал хөгжлийг дэмжих бодлого, зохицуулалтын шалгуур үзүүлэлтийн хүрээнд цахим баримтыг цаасан баримттай ижил түвшинд үйлчлүүлэх зорилгоор олон улсын шилдэг туршлагын судалгааг хийхдээ нэр бүхий 6 орон (Эстони, Солонгос, Сингапур, Япон, Европын холбоо, Америк)-ы баримтын сулдагаа хийж, энэ чиглэлийн 131 албан хаагч, мэргэжилтнүүдийн дунд санал асуулгын судалгааг хийж, төрийн 21, хувийн хэвшлийн 9 нийт 30 байгууллагын 80 орчим төлөөллийг оролцуулсан нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж, ЦХИХХЯ, ЭМЯ, АЕГ өдөр тутмын үйл ажиллагаандаа ашигладаг 200 актаас 73 эрх зүйн актад зөрүүгийн шинжилгээг хийсэн. Эдгээр судалгааг үндэслэн санал зөвлөмж боловсруулсан. Жишээ нь өөрчлөлт оруулах шаардлагатай 45 журмыг тодорхойлж, журам тус бүрээр хийгдэх өөрчлөлтийн санал, зөвлөмж, MNS5140 баримт бичгийн стандартыг олон улсын стандартын зохицуулалтын зөвлөмжийн

<sup>3</sup> Ахмад настай иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх хөтөлбөрийн сургалтад хамрагдсан ахмадын тоо

саналыг боловсруулсан. Эдгээр эрх зүйн актын өөрчлөлтийг батлуулсны дараа төслийн шалгуур үзүүлэлтийн биелэлт оруулж тооцно.

**4.4. Төсөл, арга хэмжээний хэрэгжилт**

Төслийн 1, 2, 3 дугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 2024-2027 онд нийт 59<sup>4</sup> дэд төсөл, арга хэмжээ төлөвлөснөөс хэрэгжилтийн үе шатаар авч үзвэл дараах хэрэгжилттэй байна. Үүнд төслийн удирдлага, зохион байгуулалтыг хангах 4 дүгээр бүрэлдэхүүн хэсгийг оруулаагүй болно.

| д/д | Үйл ажиллагааны хэрэгжилтийн үе шат                                                                               | Дэд төсөл, арга хэмжээний тоо |            |
|-----|-------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------|------------|
|     |                                                                                                                   | 2024.12.31 <sup>5</sup>       | 2025.12.31 |
| 1   | Эхлүүлэхээр төлөвлөгөөнд оруулсан                                                                                 | 11                            | 6          |
| 2   | Бэлтгэл хангах (ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, тендерийн баримт бичиг боловсруулах, эцэслэх, батлуулах) | 19                            | 18         |
| 3   | Худалдан авах ажиллагаа, гэрээ байгуулах                                                                          | 7                             | 2          |
| 4   | Хэрэгжиж байгаа гэрээ                                                                                             | 15                            | 13         |
| 5   | Хэрэгжиж байгаа чадавхыг бэхжүүлэх арга хэмжээ                                                                    | 2                             | 4          |
| 6   | Хэрэгжиж дууссан гэрээ, арга хэмжээ                                                                               | 1                             | 16         |

Дээрх хүснэгтээс өссөн дүнгээр харахад, тоон үзүүлэлтээр төлөвлөсөн ажлын 31%-тай тэнцэх дэд төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, тендерийн баримтыг боловсруулж, төслийн оролцогч талууд хамтран сайжруулж байна. 3%-тай тэнцэх дэд төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж байна. 22%-тай тэнцэх ажлын гэрээг хэрэгжүүлж байна. 27%-тай тэнцэх ажлын гэрээг хэрэгжүүлж дуусчээ.

Өнгөрсөн онтой харьцуулахад хэрэгжүүлж дууссан гэрээний тоо 15-аар нэмэгдсэн байна.

Төслийн хэрэгжилтийн хувь хэмжээг тоон үзүүлэлтээр буюу ажлын даалгавар, тендерийн баримт бичиг боловсруулж батлуулахад 25%, тендер шалгаруулалт явуулж гэрээ байгуулахад 20%, хэрэгжилтэд 55% зарцуулахаар тооцвол өссөн дүнгээр **63.33%** хүрээд байна. Өмнөх жилтэй харьцуулахад **34.87%-иар** өсчээ.

Төслийн хүрээнд байгуулагдсан гэрээний хүрээнд болон Төсөл хэрэгжүүлэх нэгжийн орон тоог оролцуулан төслийн хүрээнд өссөн дүнгээр 110 хүнийг түр болон байнгын ажлын байраар хангаж, хангах нөхцөлийг бүрдүүлсэн. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 88 ажлын байраар нэмэгджээ.

<sup>4</sup> 2025.12.31-ний байдлаар төслийн Удирдах хорооны шийдвэрээр төслийн нийт төлөвлөгөөнд 59 дэд төсөл арга хэмжээг тусгасан.

<sup>5</sup> 2024.12.31-ний байдлаар төслийн Удирдах хорооны шийдвэрээр төслийн нийт төлөвлөгөөнд 59 дэд төсөл арга хэмжээг тусгасан байсан.

Тайланд хугацаанд хийгдсэн голлох ажлууд:

| Үйл ажиллагаа                                                                                                                                        | Үр дүн                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 2.2.4 Интернэтийн харилцан холболтын төхөөрөмжийг шинэчлэх гэрээт ажил                                                                               | Монголын интернетийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд болон тэдгээрийн хэрэглэгчид Монгол Улс дотроо хурдны хязгаарлалтгүйгээр дотоодын цахим хуудас, цахим систем, өгөгдөл солилцох, мэдээлэл дамжуулах төхөөрөмжийн хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлсэн.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
| 3.1.2.3, 3.1.2.4-1,2,3 Ахмад настны цахим ур чадварыг нэмэгдүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх бие даасан зөвлөхүүдийн гэрээт ажил (4 гэрээ)              | Ахмад настай иргэдийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж дууссан. Хөтөлбөрт хүрээнд 137 сайн дурын ажилтныг татан оролцуулж, нийт 1,208 (давхардсан 1,277) ахмадуудыг цахим ур чадварыг нэмэгдүүлэх сургалтад хамруулжээ. Сургалтад хамрагдсан 1,208 ахмадын цахим ур чадвар дунджаар 49.9%-өссөн бөгөөд 67% нь эмэгтэй байна. Улаанбаатар хотын 9 дүүрэг төдийгүй орон нутгийн 13 аймгаас төлөөлөл хамрагдсан.                                                                                                                                                                                                                             |
| 2.2.1.1 Үндэсний дата төв болон Нөөц төвийн хүчин чадлыг өргөтгөх гэрээт ажил                                                                        | Үндэсний дата төвийн боловсруулах хүчин чадал 40%-иар, хадгалах хүчин чадлыг 50%-иар, эрчим хүчний дэд бүтцийн хүчин чадлыг 30%-иар нэмэгдүүлэх, цахим үйлчилгээний дэд бүтцийн орчныг 2027 он хүртэл найдвартай бүрдүүлэх (6.0 сая ам доллар) гэрээг хэрэгжүүлж байна. Гэрээний үнийн дүнгийн 40%-тай тэнцэх хадгалах төхөрөөмж, сүлжээ, аюулгүй байдлын тоног төхөөрөмжийг нийлүүлсэн.                                                                                                                                                                                                                                                  |
| 2.1.4.2 Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн системийг нийлүүлэх, тоног төхөөрөмжийг нийлүүлэх гэрээт ажил | Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн системд шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлж, суурилуулсан. Системийн бүх модуль (мэдүүлгийн хяналт шалгалтын модуль- <a href="#">iad.iaac.mn</a> , хайлтын нэгдсэн модуль- <a href="#">search.iaac.mn</a> , олон нийтийн портал <a href="#">hasxom.iaac.mn</a> , системийн интеграцлал <a href="#">smart.iaac.mn</a> )-ийг хөгжүүлж дууссан. Дата шилжүүлэх, системийн тест, системийн сургалт, гарын авлагыг хийж, АТГ системийг ашиглалтад хүлээн авсан. Уг системээр 2026 оны ХАСХОМ-ийн мэдүүлгийг бүрдүүлэх бөгөөд хяналт шалгалтын ажлыг хийнэ. |
| 2.2.5 Төрийн байгууллагуудын цахим шуудангийн системийн лиценз нийлүүлэх гэрээт ажил                                                                 | Төрийн байгууллагуудад ашиглагддаг цахим шуудангийн 80,000 ширхэг нэг жилийн хугацаатай лицензийг нийлүүлсэн. системийн сайжруулалтыг хийж, төрийн цахим харилцааны аюулгүй байдлыг хангалаа.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
| 2.3.1.1-1 Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвд тоног төхөөрөмж нийлүүлэх                                                                    | Гэрээг байгуулж, ажлыг эхлүүлсэн. Гэрээг хэрэгжүүлснээр мэдээллийн аюулгүй байдлыг хангах, нөөцлөх сервер, сүлжээг сегментчлэх, сэжигтэй хандалтыг халдлага, зөрчил эсэхийг таних, дата анализ хийх шийдлийг бүрэн нэвтрүүлнэ.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |

|                                                                                                                                         |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 2.3.2.1 Улсын бүртгэлийн цахим мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нууцлал, аюулгүй байдлыг сайжруулах дэд бүтцийг бий болгох гэрээт ажил | Гэрээг байгуулж, ажлыг эхлүүлсэн. Энэ гэрээг хэрэгжүүлснээр улсын бүртгэлийн системийн нөөц төвийг бүрдүүлж, гамшиг, ослын үед цахим үйлчилгээний тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах боломж бүрдэнэ. Олон улсын ISO/IEC 27001 стандартын шаардлагад нийцсэн мэдээллийн аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэж, цахим мэдээллийн эмзэг байдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх болон халдлагад хариу үйлдэл үзүүлэх чадавх бэхжинэ.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |
| 3.1.1.1 Төрийн албан хаагчдын сургалтын нэгдсэн цахим платформ surgalt.gov.mn-ийг өргөтгөн хөгжүүлэх, сайжруулалт хийх                  | Гэрээг байгуулж, ажлыг эхлүүлсэн. Гэрээг хэрэгжүүлснээр системийг өргөтгөж, ХУР системтэй холбогдох, цахим шалгалтын сайжруулалт сайжруулах, багштайгаа хоорондоо харилцах чат хөгжүүлэлт, сургалтын төлөвлөлт, гар утасны апп зэрэг модулийг нэмэгдэнэ.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
| 2.1.8.3 Засгийн газрын цахим хурлын системийг шинэчлэх, лиценз худалдан авах                                                            | Засгийн газрын цахим хурлын системийг шинэчилж, суурилуулсан. Уг хурлын систем нь нэг удаа аваад, байнга ажиллах лицензтэй бөгөөд өөрийн сервер дээр ажилладаг тул нууцлал, аюулгүй байдлыг бүрэн хангасан систем юм. Нэг агшинд хийх хурлын оролцогчдын тоо 2 дахин нэмэгдэж, 200 болгон шинэчилсэн.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
| 1.1.3 Цахим шилжилт хийхэд шаардлагатай дүрэм журмуудын хийдэл, зөрчлийг тогтоож, санал боловсруулах гэрээт ажил                        | Дижитал хөгжлийг дэмжих бодлого, зохицуулалтын шалгуур үзүүлэлтийн хүрээнд цахим баримтыг цаасан баримттай ижил түвшинд үйлчлүүлэх зорилгоор олон улсын шилдэг туршлагын судалгааг хийхдээ нэр бүхий 6 орон (Эстони, Солонгос, Сингапур, Япон, Европын холбоо, Америк)-ы баримтын сулдагаа хийж, энэ чиглэлийн 131 албан хаагч, мэргэжилтнүүдийн дунд санал асуулгын судалгааг хийж, төрийн 21, хувийн хэвшлийн 9 нийт 30 байгууллагын 80 орчим төлөөллийг оролцуулсан нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж, ЦХИХХЯ, ЭМЯ, АЕГ өдөр тутмын үйл ажиллагаандаа ашигладаг 200 актаас 73 эрх зүйн актад зөрүүгийн шинжилгээг хийсэн. Эдгээр судалгааг үндэслэн санал зөвлөмж боловсруулсан. Жишээ нь өөрчлөлт оруулах шаардлагатай 45 журмыг тодорхойлж, журам тус бүрээр хийгдэх өөрчлөлтийн дүгнэлт, зөвлөмж, MNS5140 баримт бичгийн стандартыг олон улсын стандартын зохицуулалтын зөвлөмжийн саналыг боловсруулсан. |
| 2.2.6 Үүлэн тооцооллын үйлчилгээг ашиглах судалгааг хийх гэрээт ажил                                                                    | Монгол Улсын төрийн салбарт үүлэн технологийн шинэчлэл хийх стратегийн шаардлага, “Үндэсний дата төв” УТҮГ-ын одоогийн дэд бүтэц, системийн үнэлгээ, виртуалчлалын үйлчилгээ үзүүлэгчдийн техникийн болон эрх зүйн нийцэл, үүлэн шийдлүүд(хувийн, нийтийн, хосолмол)-ийн харьцуулалт, Сингапур, АНУ, Өмнөд Солонгос улсуудын сайн туршлагыг Монгол Улстай харьцуулсан судалгаа, үүлэн технологийн санхүүгийн шинжилгээг хийж, хууль эрх зүйн орчны                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |

|                                                                                                                                                                                                                                                                                                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                                                                                                                                                                                                                                      | судалгаа, үүлэн тооцооллын үйлчилгээний тэргүүлэх чиглэл, хамаарал, технологийн үнэлгээ, шилжилтийн стратегийн тайланг боловсруулсан.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| 2.1.2.1 Цахим худалдан авах ажиллагааны системийн техникийн бие даасан зөвлөхийн гэрээт ажил                                                                                                                                                                                                         | Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийг сайжруулах ажлын төслийн техникийн тодорхойлолтыг боловсруулж, эцэслэсэн. Тендерийн баримт баримт бичгийг боловсруулахад дэмжлэг үзүүлж, эцэслэсэн. Дэлхийн банкны буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж байгаа “Төрийн худалдан авах ажиллагааны системийн хиймэл оюун ухааны шийдэл” тусдаа төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. Төслийн 2-р бүрэлдэхүүн хэсгийн зарим дэд төслийн техникийн тодорхойлолтыг үр шим хүртэгч байгууллагуудтэй хамтран боловсруулж байна. |
| 2.1.2.4-1 Худалдан авах ажиллагааны сургалттай холбоотой журам, зааварчилгаа, баримт бичгийг хянах, сайжруулах, шинэчлэх бие даасан зөвлөхийн гэрээт ажил                                                                                                                                            | ТБОНӨХБАҮХА тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн худалдан авах ажиллагааны 25 сэдэв бүхий 4 модультай иж бүрэн гарын авлагыг боловсруулж, tender.gov.mn-д байршуулсан. Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтын журмыг боловсруулсан бөгөөд батлуулж байна.                                                                                                                                                                                                                                  |
| 2.1.2.4-2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн журам, заавар боловсруулах, хуулийн талаар сонирхогч талуудын мэдлэг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх бие даасан зөвлөхийн гэрээт ажил | ТБОНӨХБАҮХА тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн 12 захиргаа хэм, хэмжээний актыг шинэчлэн батлуулж, үүнд 9 тендерийн жишиг баримт бичгийг шинэчилжээ. Худалдан авалтын баримт бичгийн шинэчлэлийн талаар мэдээлэл өгөх сургалтуудыг хийсэн. Дээрх хуулийг шинэчлэх ажлын хэсэгт мэдээлэл танилцуулга хийж, хамтран ажиллаж байна.                                                                                                                                                                                |
| 2.1.2.4-3 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу гомдол шийдвэрлэх механизмд дүн шижилгээ хийх, худалдан авах ажиллагааны улсын байцаагчид дэмжлэг үзүүлэх бие даасан зөвлөхийн гэрээт ажил                       | ТБОНӨХБАҮХА тухай хуулийн гомдол хянан шийдвэрлэх механизмд дүн шинжилгээ хийх чиг үүргийн хүрээнд гадаад, дотоодын нөхцөл байдалд харьцуулсан шинжилгээ хийж, холбогдох хуулийн төсөлд тусгах асуудлын талаар санал, томъёоллын төслийг боловсруулсан. 2024 оны жилийн эцсийн статистик тоон мэдээллийг үндэслэн тендерийн маргаан, гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааг сайжруулах санал, зөвлөмж гаргасан.                                                                                                               |
| 1.1.1 Дижитал шилжилтийн бие даасан зөвлөхийн гэрээт ажил                                                                                                                                                                                                                                            | Зөвлөх нь Цахим шилжилтийг дэмжих 2 хууль, 3 дүрмийг боловсруулах ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, батлуулсан. Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хоёр ажлын даалгаврыг боловсруулж эцэслэсэн.                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
| 3.1.2.1 Дижитал эдийн засгийн бие даасан зөвлөхийн гэрээт                                                                                                                                                                                                                                            | Дижитал эдийн засгийг дэмжих бүрэлдэхүүн хэсэг 3-ын хүрээнд хэрэгжүүлэх дэд төслийн 7 ажлын                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |

|                                                                                                                                                                                                                                                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| ажил                                                                                                                                                                                                                                                      | даалгаврыг боловсруулж, эцэслэсэн. Ахмад настай иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хяналт тавьж ажилласан.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| 2.1.3.3-1, 2 Зөвшөөрлийн нэгдсэн сангийн системийн загварыг шинэчлэн боловсруулах хүрээнд аймаг, нийслэлийн засаг даргын эрх, үүргийн дагуу тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд процессын шинжилгээ хийх бие даасан зөвлөхүүдийн гэрээт ажил (2 гэрээ) | 49 тусгай зөвшөөрлийн процессын шинжилгээг хийж, 186 одоогийн, 212 шинэ процессын зураглалыг хийсэн.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
| 2.1.3.4 Зөвшөөрлийн нэгдсэн сангийн системийн загварыг шинэчлэн боловсруулах хүрээнд аймаг, нийслэлийн засаг даргын эрх, үүргийн дагуу тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд процессын шинжилгээ хийхэд хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх                 | 15 тусгай зөвшөөрлийг олгох процессыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцэж байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор хууль, эрх зүйн баримт бичгийг судалгааг хийж, одоо (as-is)-гийн процессын зураглалтай танилцаж, эдгээр зөвшөөрлийн хууль, эрх зүйн зохимжит процессын зураглал, тайлбар, одоогийн процесс нь холбогдох хууль, эрх зүйн актад нийцэж байгаа эсэх харьцуулалт, зөвшөөрөл хүсэхэд шаардаж байгаа баримтууд нь холбогдох эрх зүйн актаар тогтоосон шаардлагад нийцэж байгаа эсэх харьцуулалтыг хийж, санал, зөвлөмж гаргасан. |

Төслийн 2025 оны үйл ажиллагаа (гүйцэтгэлийн)-ны төлөвлөгөөний биелэлт нийт ажлын дундажаар **81.8%-тай** байна. Төлөвлөгөөний биелэлт “хангалттай” гэж дүгнэж байна.

### **5.Байгаль орчин**

Төслийн байгаль орчны эрсдэлийг “Дунд зэрэг/moderate” гэж үнэлсэн. Төслийн хүрээнд хэрэгжүүлэх хэрэгжүүлэх үйл ажиллагааны төрөл, хамрах хүрээнээс дүгнэхэд байгаль орчинд үзүүлж болзошгүй эрсдэл, нөлөөлөл нь түр зуурынх бөгөөд тухайн ажлын талбайд болон бага хэмжээний газар нутагт хамаарна. Төслийн хүрээний хөрөнгө оруулалтад зөвхөн мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн худалдан авалт, суурилуулалт болон бага хэмжээний барилгын ажил багтана. “Бага хэмжээний барилгын ажил”-д сувагчлал гаргах, байршуулах, цахилгааны дулаалга хийх зэрэг бага хэмжээний барилгын ажил орно.

Байгаль орчны дээрх эрсдэлийн үнэлгээнд нийцүүлэн Дэлхийн банкны стандартын дагуу төслийн хүрээнд мөрдөгдөх Байгаль орчны талаар баримтлах журам, Байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Байгаль орчин, нийгмийн эрсдэлийг хянах, эрсдэлийг үнэлэх, түүний үр нөлөөг нь бууруулах арга хэмжээг дээрх журам, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ. Эдгээрийг боловсруулахдаа төслийн оролцогч талууд болон олон нийтэд нээлттэй танилцуулж<sup>15</sup>, иргэд, төрийн байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллөөр хэлэлцүүлж, санал авсан. Мөн төслийн хэрэгжүүлэгч

байгууллага Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны дахин нээлттэй нийтэлж<sup>16</sup> нэмэлт санал ажлыг зохион байгуулсан. Эдгээр баримт бичгийг төслийн вебсайтад байршуулсан<sup>17</sup>.

Байгаль орчин, нийгмийн хамгааллын хүрээнд хийгдсэн ажлыг 6 сар тутамд Дэлхийн банкинд тайлагнаж байна. Эхний тайланг 2025 оны 10-р сарын 30-наар хүргэсэн.

## 6. Төслийн хэрэгжилтийн үнэлгээ

### 6.1. Төслийн хэрэгжилтийн үзүүлэлт

Төслийн хэрэгжилтийг үнэлэхдээ Төслийн Удирдах хороогоор баталсан 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан болон өмнө нь төлөвлөж 2025 онд хэрэгжүүлэхээр хойшлуулсан нийт 55 ажлыг үнэлж, үнэлгээнд тооцов.

Төслийн хэрэгжилтийн үндсэн үзүүлэлтүүдийн биелэлтийг үзүүлбэл:

| Д/д | Үзүүлэлт                                                                                                                                                                          | 2024.12.31 | 2025.12.31               |
|-----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|--------------------------|
| 1   | Төслийн 2024-2027 оны төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийн хувь (өссөн дүнгээр)                                                                                      | 28.46%     | 63.33%                   |
| 2   | Төсөл арга хэмжээний нийт санхүүжилтэд эзлэх хувь хэмжээг тус бүрийн хэрэгжилтэд харгалзуулж тооцсон төслийн нийт ажлын гүйцэтгэлийн хувь (өссөн дүнгээр)                         | 11.58%     | 24.12%                   |
| 3   | Зээлийн ашиглалтын хувь (өссөн дүнгээр)                                                                                                                                           | 10.4%      | 16.6%                    |
| 4   | Төслийн нийт зарцуулалтын хувь (өссөн дүнгээр)                                                                                                                                    | 1%         | 11%                      |
| 5   | Ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, тендерийн баримт бичигт нь Дэлхийн банкнаас албан ёсны зөвшөөрөл авч, эцэслэсэн дэд төслийн тоо (өссөн дүнгээр)                          | 24         | 36<br>(41 <sup>6</sup> ) |
| 5.a | Ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, тендерийн баримт бичигт нь Дэлхийн банкнаас албан ёсны зөвшөөрөл авч, эцэслэсэн дэд төслийн нийт санхүүжилтэд эзлэх хувь (өссөн дүнгээр) | 28.1%      | 35.58%                   |
| 6   | Худалдан авалтыг нь зохион байгуулсан болон зохион байгуулж байгаа дэд төслийн тоо (өссөн дүнгээр)                                                                                | 23         | 32                       |
| 6.a | Худалдан авалтыг нь зохион байгуулсан болон зохион байгуулж байгаа дэд төслийн нийт санхүүжилтэд эзлэх хувь (өссөн дүнгээр)                                                       | 24%        | 27%                      |
| 7   | Байгуулагдсан гэрээний тоо (өссөн дүнгээр)                                                                                                                                        | 16         | 29                       |
| 7.a | Байгуулагдсан гэрээний нийт дүн (өссөн                                                                                                                                            | 997,521    | 11,227,826               |

<sup>6</sup> Цуцалсан дэд төслүүд болон нэмэлт гэрээний ажлын даалгаврыг оруулсан дүнгээр.

|     | дүнгээр)                                                                                         | ам.доллар           | ам.доллар              |
|-----|--------------------------------------------------------------------------------------------------|---------------------|------------------------|
| 7.б | Байгуулагдсан гэрээний дүн нийт санхүүжилтэд эзлэх хувь (өссөн дүнгээр)                          | 2.39%               | 26.93%                 |
| 8   | Хэрэгжүүлж дууссан, дуусгавар болгосон гэрээний тоо (өссөн дүнгээр)                              | 1                   | 16                     |
| 8.а | Хэрэгжүүлж дууссан, дуусгавар болгосон нийт гэрээний дүн (өссөн дүнгээр)                         | 36,110<br>ам.доллар | 1,146,596<br>ам.доллар |
| 8.б | Хэрэгжүүлж дууссан, дуусгавар болгосон гэрээний дүн нийт санхүүжилтэд эзлэх хувь (өссөн дүнгээр) | 0.09%               | 2.75%                  |
| 9   | Ажлын байрны тоо (түр болон байнгын, өссөн дүнгээр)                                              | 22                  | 88                     |

Төслийн 2024-2027 онд 1, 2, 3 дугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд нийт 59 дэд төсөл, арга хэмжээ төлөвлөсөн. Эдгээр 3 бүрэлдэхүүн хэсгийн хэрэгжилт дундаж (тоон үзүүлэлт) 63.3%, өнгөрсөн оны мөн үеэс 2 дахин өсчээ.

Санхүүжилтэд эзлэх хувийн жингээр буюу чанарын үзүүлэлтээр төслийн нийт ажлын гүйцэтгэл 24.12% байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 2 дахин өсчээ.

Төслийн 2025 оны үйл ажиллагаа (гүйцэтгэл)-ны төлөвлөгөөний биелэлт 81.8% байна.

Тайлант хугацааны эцсийн байдлаар төслийн хүрээнд өссөн дүнгээр 3,325,216.10 ам.доллар зарцуулсан нь нийт санхүүжилтийн 11 хувь байна. Өмнө оноос 8 дахин өсчээ.

Төслийн зээлийн ашиглалт өссөн дүнгээр 16.6% байгаа өнгөрсөн оны мөн үеэр 6 хувиар нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд хийгдсэн ажлыг нийт санхүүжилтэд эзлэх хувиар дүгнэж үзвэл, өссөн дүнгээр нийт санхүүжилтийн 35.58%-тай тэнцэх дэд төслийн ажлын даалгавар, тендерийн баримт бичигт нь Дэлхийн банкнаас албан ёсны зөвшөөрөл авч, эцэслэсэн. Үүнээс 27%-тай тэнцэх дэд төслийн худалдан авалтыг нь зохион байгуулж байгаа бөгөөд 26.96%-тай тэнцэх дэд төслийн гэрээг байгуулсан байна.

---oOo-